МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
07 ДУГААР САРЫН ХЭРЭГЖИЛТ

2023 оны 08 дугаар сарын 02 Улаанбаатар хот

| Дугаар | ХБТББ-т тусгагдсан зорилт | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Үндсэн хэрэг жүүлэгч байгууллага | Эх үүсвэр | Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг) | Суурь түвшин | Зорилтот түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ эх үүсвэр) | | | Хэрэгжилтийн явц | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Төсөв (сая төг) | Төсвийн гүйцэтгэл (сая төг) | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 |
| Бүлэг 3. Иргэн төвтэй хөгжлийг дэмжсэн засаглалын бодлого | | | | | | | | | | | | |
| 1 | МУХТЖҮЧ-5.3.2, 5.3.4, ЗГҮАХ-4.5.1 | Цахим засаглалын тогтолцоог боловсронгуй болгож, төрийн үйлчилгээний бүтээмж, үр ашгийг дээшлүүлэх | 2023 | Хууль зүй, дотоод хэргийн яам, Гадаад харилцааны яам | Улсын төсөв | - | - | Цахим виз олгох улсын тоог нэмэгдүүлэх арга хэмжээний хэрэгжилт 100 хувь | - | 0 | Монгол Улсын Засгийн газраас 2023-2025 оныг “Монголд зочлох жил” болгон зарласантай холбогдуулан Засгийн газрын 2023 оны 01 дүгээр тогтоолоор Монгол Улсын цахим виз олгох улсын жагсаалтад багтаж байсан Европын улсууд болон Австрали, Шинэ Зеланд зэрэг 34 улсын иргэдийг визийн шаардлагаас чөлөөлөн, Гадаад харилцааны сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн А/09, А/53 дугаар хамтарсан тушаалаар 98 улсыг цахим виз олгох улсын жагсаалтад нэмснийг “Визийн мэдээллийн нэгдсэн сан” (evisa.mn) | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | системд бүрэн нэвтрүүлж, нийт 99 улсын иргэнд цахим визийг олгохоор зохицуулсан.<br>Энэ оны өссөн дүнгээр 80 улсын 14776 иргэнд цахим виз олгосноос Гадаад харилцааны сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны А/09, А/53 дугаар хамтарсан тушаалыг мөрдөж эхэлснээс хойш тайлант хугацаанд “Визийн мэдээллийн нэгдсэн сан” систем (evisa.mn)-ээр нийт 14240 гадаадын иргэнд цахим виз олгосон байна. | |

--oo0oo--